



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 515

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Усны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 87,600,000.00 (наян долоон сая зургаан зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 59,616,666.72 (тавин есөн сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийн хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006175  
27-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 10 дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

Усны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (2023оны 09 сарын 30ны өдрөөр) (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Ланд крузер-76 84-99 УНУ	2017/2017	87,600,000.00	59,616,666.72	27,983,333.28	42,600,000.00	21,300,000.00
			87,600,000.00	59,616,666.72	27,983,333.28	42,600,000.00	21,300,000.00
Нийт дүн			(наян долоон сая зургаан зуун мянга)	(тавин есөн сая зургаан зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө)	(хорин долоон сая есөн зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин найман мөнгө)	(дөчин хоёр сая зургаан зуун мянга)	(хорин нэгэн сая гурван зуун мянга)